



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 14 өдөр

Дугаар A/187

Арвайхээр сум

Г Бүтэц, орон тоонд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3. дахь заалт, Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 417 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг батлах тухай” 415 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдаж, эрүүл мэндийн хяналтын чиг үүрэг тус газарт шилжсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн “Эрүүл мэндийн газрын дүрэм, бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн тогтоох тухай” A/181 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтаар баталсан “42” гэснийг “46” гэж өөрчилж, шинээр нэмэгдсэн орон тоог хавсралтаар баталсугай.

2. Бүтэц, орон тоонд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0212

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар
сарын 11-ны өдрийн 11:22 дугаар
захирамжийн хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТООНЫ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

№	Албан тушаалын нэр	Орон тоо
Хяналт- шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэст		
1.	Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч	1
2.	Эмийн чанар, аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч	1
3.	Эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын улсын байцаагч (хүнсний эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналт)	1
4.	Эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын улсын байцаагч (орчны эрүүл ахуйн хяналт)	1
	Бүгд	4

-оOo-